

БАТЛАВ:

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН
ГАЗРЫН ДАРГА

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“БАС ГОВЬ ГРУПП” ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Б.ЦЭВЭЭН

“БАС ГОВЬ ГРУПП” ХХК-ИЙН ГОВЬСҮМБЭР АЙМАГ, СҮМБЭР СУМАНД ХЭРЭГЖИХ
“АЧИЛТ БУУЛГАЛТЫН ЛОЖИСТИК ТӨВ” ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 4279344

ХЯНАСАН:

ХБОБХГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

П.ШИНЭЦЭЦЭГ

БОЛОВСРУУЛСАН:

“БАС ГОВЬ ГРУПП” ХХК

Д.ЖАРГАЛМАА

2025 ОН

АГУУЛГА

ОРШИЛ

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

- 1.1. Төслийн нэр
- 1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага
- 1.3. Төслийн байршил
- 1.4. Төслийн үйл ажиллагааны товч танилцуулга
- 1.5. Төслийн техник технологи
- 1.6. Төслийн барилга байгууламж, дэд бүтцийн шийдлийн мэдээлэл

ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

- 2.1. Төсөл хэрэгжих нутгийн цаг уур, уур амьсгалын нөхцөл
- 2.2. Газрын гадарга
- 2.3. Агаарын чанар
- 2.4. Гадаргын болон газрын доорх ус
- 2.5. Хөрсөн бүрхэвч
- 2.6. Ургамлан нөмрөг
- 2.7. Амьтны аймаг
- 2.8. Нийгэм эдийн засгийн үзүүлэлт

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

- 3.1. Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүд
- 3.2. Төслийн гол сөрөг нөлөөлөл

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ДОЛОО. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

НАЙМ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

АРВАН ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

ОРШИЛ

“Бас говь групп” ХХК нь 2021 оны 05 дугаар сараас Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд “Ачилт буулгалтын ложистик төв” төслийн үйл ажиллагааг эхлүүлсэн. Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Засаг даргын 2018 оны 07 сарын 26-ны өдрийн А/247 тоот шийдвэрээр Сүмбэр сумын 1 дүгээр баг, Үйлдвэрлэл гудамж 119 тоот хаягт үйлдвэрлэлийн зориулалтаар 10.3 га газрыг 15 жилийн хугацаатайгаар эзэмшсэн.

Манай компаний хэрэгжүүлж буй энэхүү төсөл нь нэг цэгээс нөгөө цэг рүү өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, барилга, уул уурхайн салбарын том оврын тоног төхөөрөмж болон манай улсын нутгаар дайран өнгөрөх транзит ачааг шилжүүлэн ачиж тээвэрлэх, төмөр замын тээвэрлэлттэй холбоотой гаалийн бүрдүүлэлт хийх, терминал өргөлт, буулгалт, дотоод түгээлтийн үйлчилгээнүүдийг давхар хийж гүйцэтгэх зорилготой.

Нийт нэг дор 100 вагон хүлээн авах хүчин чадалтай 4 салаа төмөр замтай бөгөөд бүх төрлийн ачаа буулгах өндөрлөсөн тавцан, задгай вагоноос хүнд даацын машин техник шууд хөлөөр нь буулгах тавцан, гаалийн дулаан агуулах, оффисын болон ажилчдын байр зэрэг барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулсан.

Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг “Нью грийн ворлд” ХХК боловсруулан Байгаль орчин аялал жуулчлалын яамаар 2022 онд баталгаажуулсан.





НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр

“Ачилт буулгалтын ложистик төв” төсөл.

1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага

Төсөл хэрэгжүүлэгч: “Бас говь групп” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9011840315

Регистрийн дугаар: 4279344


Хаяг: Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 1-р баг, Үйлдвэрлэл гудамжны 119 тоот

Утас: 99199477

1.3. Төсөл хэрэгжих талбайн байршил

“Бас говь групп” ХХК-ийн “Ачилт буулгалтын ложистик төв” төсөл нь Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутаг дэвсгэрт, сумын төвийн баруун урд талд байрлах бөгөөд Улаанбаатар хотоос зүүн өмнө зүгт 250 км-ийн зайд 10.3 га талбайг эзэмшин үйл ажиллагаа явуулж байна.

Төслийн талбайн байршил



1.4. Төслийн үйл ажиллагааны товч танилцуулга

“Ачилт буулгалтын ложистик төв” нь тээвэрлэж ирсэн ачаа бараа, уул уурхайн бүтээгдэхүүнийг стандарт журмын дагуу аюулгүй, найдвартай зориулалтын талбайд буулгаж хадгалах, гаалийн бүрдүүлэлт хийн гаргах үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 4 салаа төмөр замтай, нэг дор 100 вагон нэгэн зэрэг хүлээн авах бүрэн хүчин чадалтай.

Бүх төрлийн ачаа буулгах өндөрлөсөн тавцан, задгай вагоноос хүнд даацын машин техник шууд хөлөөр нь буулгах тавцан, талбай дотор задгай ачаа хадгалах зориулалт бүхий агуулах, оффисын барилга, вагон пүү, электрон авто пүү, 4500м² талбайтай бүх төрлийн энгийн болон гаалийн баталгаат дулаан агуулах зэргийг барьж ашиглалтад оруулсан.

1.5. Төслийн техник технологи

Төслийн үйл ажиллагаанд дараах тоног төхөөрөмжийг ашиглаж байна. Үүнд:

- Дугуйт ачигч /ковш/ - 3ш
- Сэрээт ачигч - 1ш
- Вагон пүү – 1ш /200тн даацтай, 40м урттай/
- Авто пүү – 1ш /150тн даацтай/

1.6. Төслийн барилга байгууламж, дэд бүтцийн шийдэл

- Уламжлалт задгай болон чингэлэгтэй түүхий эд хүлээн авах, ачих, буулгах талбай
- Оффисын болон ажилчдын амрах байр
- Орох болон гарах хаалганы шалган нэвтрүүлэх харуулын байр
- Авто пүү болон пүүлэгчийн байр
- Вагон пүү болон пүүлэгчийн байр
- Ачилт буулгалтын ложистик төвийн хашаа
- Гэрэлт цамхгууд /тусгай зориулалтын/
- Бохирын цооног
- Агуулах
- Авто зогсоол
- Гүний худаг

Цахилгаан хангамжийн эх үүсвэр: Цахилгаан, эрчим хүчээ “Багануур Зүүн Өмнөд Бүсийн Цахилгаан Түгээх Сүлжээ” ТӨХК-тай гэрээ байгуулж хангадаг.

Дулаан хангамж: Дулаан хангамжийн эх үүсвэрийг нам даралтын зуухаар шийдвэрлэсэн.

Ус хангамжийн эх үүсвэр: Өөрийн эзэмшлийн талбайд байрлах гүний худгаас ус ашиглах бөгөөд технологийн хэрэгцээнд ус ашиглахгүй, ажилчдын унд ахуй болон ногоон байгууламжийн усалгааны зориулалтаар ус ашиглана.

ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Төсөл хэрэгжих нутгийн цаг уур, уур амьсгалын нөхцөл

Төслийн талбай нь Монгол орны хамгийн дулаан бүсэд багтдаг бөгөөд уур амьсгалын мужлалаар хэт халуун хуурай зунтай, хүйтэн, хуурай өвөлтэй мужид багтана. Цаг агаарын хэмжилтийн дүнгээс үзэхэд зуны улирлын агаарын дундаж температур $+20^{\circ}\text{C}$ байх бол өвлийн улирлын дундаж температур -17°C орчим бол жилийн дундаж температурын хэмжээ $+3^{\circ}\text{C}$ орчимд хэлбэлзэнэ.

Жилд дунджаар 90-100мм орчим хур тунадас унах бөгөөд нийт хур тунадасын 80% зөвхөн дулааны улиралд 4-р сараас 10-р сарын хугацаанд ногдоно. Хур тунадасны ихэнх хувь нь дулааны улиралд унах учир өвлийн улиралд цастай өдрийн 1-3 орчим байх бөгөөд тогтвортой цасан бүрхүүл тогтдоггүй байна.

Салхитай өдрийн тоо жилд 30-40 орчим байх бөгөөд үүнээс шороон шуургатай өдрийн 40 дээш орчим буюу нийт жилийн турш маш их хүчтэй салхины нөлөөнд оршдог байна. Уур амьсгалын нөхцөлийн хуурай-чийг багатай, хүчтэй салхины нөлөөнд оршдог шинж нь төслийн талбайн хөрсөн бүрхэвчийг хуурай, элсэн фракц давамгайлсан, органик бодисын нөөц багатай, давсны агууламж өндөр, карбонатын агууламж их зэргээр илэрдэг.

2.2. Газрын гадарга

Төсөл хэрэгжих талбай орчмын хөрс үүсгэгч эх чулуулаг нь пролювийн элс, элсэнцэр хурдасаас тогтоно. Ийм гаралтай пролювийн хурдас нь Монголын дорнод хэсгийн элэгдэл-хуримтлалын гаралтай ухаа гүвээт тал болон тэгшивтэр талуудад түгээмэл тохиолдоно. Эдгээр хурдас нь элс, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, карбонатын агууламж өндөртэй, хөрсний үе давхаргуудад элсэн фракцийн агууламж өндөр, нам дор газруудад хүнд шавранцар бүтэцтэй байдаг.

2.3. Агаарын чанар

“Ачилт буулгалтын ложистик төв” төслийн талбай нь Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт байрлана. Төсөл хэрэгжих бүс нутаг нь уур амьсгалын хувьд хуурай, чийг дутмаг, хур тунадас бага ордог тул агаар бохирдуулагч үндсэн эх үүсвэрүүд нь сул шороо бүхий хөрснөөс салхины үйлчлэл болон машин техникийн нөлөөллөөр тоосжилт үүсэх, мөн техник хэрэгслийн дутуу шаталтат хөдөлгүүрээс агаарт хорт хий ялгарах, ахуйн хатуу, шингэн хаягдлаас агаарт бохирдол тархах зэрэг хүчин зүйлс байх юм.

Хот суурин газрын агаарын чанарын хяналт шинжилгээнд ихэвчлэн түлшний шаталтаас үүдэлтэй зарим бохирдуулагч бодисуудыг сонгон тодорхойлдог. Эдгээрээс хамгийн түгээмэл илэрцтэй бохирдуулагч бодисууд нь тоос тоосонцор, хүхэрлэг хий, азотын давхар исэл, нүүрстөрөгчийн дутуу исэл юм.

Төсөл хэрэгжих талбайн орчимд гаалийн баталгаат агуулах болон нефтийн агуулахууд үйл ажиллагаа явуулж байгаа нь тэдгээрийн үйл ажиллагаанаас үүдэлтэй агаарын болон орчны бохирдлын хуримтлагдах нөлөөлөлд өртөмтгий байх магадлалтай.

Ялангуяа салхины нөлөөллөөр элэгдэл эвдрэлд өртсөн зам талбайгаас салхины үйлчлэл болон механик ажлын нөлөөгөөр тоосжилт үүсэх, машин тоног төхөөрөмжийн ажиллагаатай холбоотой дуу шуугианы түвшин нэмэгдэх, машин тоног төхөөрөмжийн дутуу шаталтат хөдөлгүүрээс хийн төлөвт бохирдуулагч ялгарах нөхцөлтэй юм.

2.4. Гадаргын болон газрын доорх ус

Төсөл хэрэгжих талбайн орчинд гадаргын усан сүлжээ байхгүй. Харин Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэр буюу Чойрын хотгорын хүрээнд тэгш тал гадаргуутай хэсэгт шорвог, хужирлаг нуур, хуурай тойрмууд тохиолдоно. Ихэнх нууруудын эрдэсжилт нь агаарын тунадастай холбоотой өөрчлөгдөнө. Бороо орсны дараа хүчтэй цэнгэгжээд, бороогүй үед 38-66 г/л эрдэсжилттэй шорвог устай байна. Нуурын эрэг нь налуу, заримдаа намгархуу, дэрс, зэгсээр хүрээлэгдсэн. Нууруудын гүн 0,5-1,5м хэлбэлзэлтэй ба томоохон нууруудаас дурьдвал Сэвхүүлийн улаан нуур, Бэхтийн улаан нуур, Нэртийн нуур гэх мэт болно.

Төсөл хэрэгжих бүс нутаг нь Монгол улсын гидрогеологийн бүсчилээр зүүн Монгол гидрогеологийн бүсийн говийн мужийн хойт хэсэгт байрлана. Энэ мужид ихэвчлэн уулс хоорондын геологийн бүтцүүдэд хөрсний ус тархсан байдаг.

2.5. Хөрсөн бүрхэвч

Төсөл хэрэгжих талбай нь Монгол орны хөрс газарзүйн мужлалаар Хангайн их мужийн Хар хүрэн хөрсний дэд бүс Бүрэн, Баянцагааны 3-р тойргийн нутагт, Монгол орны хөрсний ангилалаар **Хуурай хээрийн хэв шинжийн, ердийн хүрэн хөрсний** төрөлд хамаарагдана.

Хуурай хээрийн бүс. Хуурай хээрийн бүсийн өмнөд хэсгээр, эсвэл хар хүрэн хөрстэй талархаг нутгийн доторхи уудам хотгоруудад харгана бүхий үетэн, агь-үетэнт ургамалжилттай газраар тархах бөгөөд ургамал нөмрөгийн бүрхэц 30-50 хувь байна. Хөрсний чийгийн хангамж төдий л сайн биш, зуны хамгийн их хур бороотой үед хөрсөнд дөнгөж 20-40см хүртэл нэвчдэг тул түүнээс доошхи хэсэг нь хуурай голдуу байна. Хөрсний үе давхарга үүнээс гүн чийглэгдэх нь ховор. Хүрэн хөрс өвлийн улиралд 2.8-3.5 м хүртэл гүн хөлдөх авч -10°C-ын температур 60 см-ээс доош бараг нэвтэрдэггүй ажээ. Зуны цагт хөрс хүчтэй халж +10°C-ын температур 2м хүртэл буюу түүнээс гүн нэвтэрдэг. Энэ бүгдээс харахад хүрэн хөрсний чийг дулааны горим хар хүрэн хөрснийхөөс их ялгаатай.

Төслийн талбайн орчны хөрсний элэгдэл, эвдрэл, бохирдлын өнөөгийн түвшин

Төсөл хэрэгжих талбай нь хүний үйл ажиллагаа болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөний улмаас өнгөн хөрс нь элэгдэж, үржил шимийн түвшин багассанаас гадна,

хатуу хог хаягдлаар бохирдож доройтсон байдалтай байна. Энд тархсан хөрсийг эвдрэлийн зэрэглэлээр нь авч үзвэл сулаас дунд зэрэглэлд орох бөгөөд хүний үйл ажиллагаа хүчтэй нөлөөлсөн байна.



Төслийн талбай дахь хөрсний бохирдол, доройтлын өнөөгийн байдал

2.6. Ургамлан нөмрөг

Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэр нь далайн түвшнөөс дээш 1250-1700м өндөрт өргөгдсөн хойт хэсгээр Дундад Халхын хээрийн хэвшинж, өмнөд хэсгээр Дорноговийн цөлөрхөг хээрийн нөлөө орсон, зүүн болон зүүн урд хэсгээр бэсрэг уулс, ухаа гүвээ толгодын ландшафтай нийтдээ тал хөндий, хотос хонхордуу газар зонхилон тархана.

Ургамалжилтын хувьд толгодын ар хажуу хэсгээр харгана-алаг өвст, тал хөндийн хэсгээр маш сийрэг алаг өвст, хотос хонхороор дэрс-хиагт, дэрс-улалжит хээрийн ургамал зонхилно.

Хойноос зүүн өмнөд хэсгийг дагаж хуурай хээрийн дэгнүүлт үетэнт, хялгана-жиижг дэгнүүлт үетэнт, хялгана-агьт хээр, зүүн хойт хэсэгт сайр чулуурхаг хар хүрэн, хүрэн хөрстэй чулуусаг элдэв өвс-хялганат хээр, өмнөд хэсгээр говийн бор хөрстэй хялгана-хазаар өвст, хялгана-таана-баглуурт цөлөрхөг хээр нэвтэрч ордог онцлогтой. Тус аймгийн хэмжээнд Ботаникийн хүрээлэнгийн эрдэмтэд судалгаа хийж, 42 овгийн 116 төрөлд хамаарах 187 зүйл ургамлыг бүртгэсэн байна.

Төсөл хэрэгжихээр төлөвлөж буй талбайн ургамлан нөмрөг нь хүн, мал, тээврийн хэрэгслийн нөлөөллөөр талхлагдан доройтож тачир сийрэг болсоноос гадна зарим хэсгийн ургамлан нөмрөг нь бүрэн устсан байдалтай байна. Уг талбайд саман дурваа, гичгэнэ, шарилж зэрэг зүйлийн ургамлууд маш тачир сийрэг ургамалтай байх бөгөөд хөрсөн бүрхэвч нь элсэн хучаастай байна.

2.7. Амьтны аймаг

Төсөл хэрэгжүүлж буй төслийн талбай нь тал хээрийн шинжийг илтгэх бөгөөд тус нутаг нь амьтны аймгийн мужлалаар Хээр, цөлөрхөг хээрийн мужийн Монгол дагуурын тойрогт хамаарагдана. Энэ тойргийн хувьд хээрийн зөвхөн энэ бүсэд дасан зохицсон амьтад ихэнх байр суурийг эзлэн оршдогоороо бусад биотопоос ялгардаг

онцлогтой. Үүнд: үлийн цагаан оготно, шар чичүүл, дагуур зурам, дагуурын огдой, туурайтнаас цагаан зээр, махчдаас өмхий хүрэн, хярс, үнэг зэрэг зүйлүүд зонхилно.

Шавж: Тус нутгийн шавжийг тусгайлан судалж байгаагүй бөгөөд Монгол-Оросын хамтарсан биологийн экспедицийн шавж судлалын отряд тус нутгаар аялал, судалгаа хийх явцдаа 8 багийн 106 зүйл шавж тэмдэглэсэн байна.

Хоёр нутагтан, мөлхөгчид: Судалгааны талбай түүний ойр орчимд хоёр нутагтан амьтад илрээгүй. Харин мөлхөгчдийн багийн амьтадаас хонин гүрвэл элбэг тохиолдоно.

Шувуу: Энэ нутагт тал хээрийн шувууд голлон амьдарна. Мөн дан ганц тал хээр тохиолддог шувуудаас гадна ус намгархаг газрын шувууд болон хот суурин газарт дайралддаг шувууд түгээмэл ажиглагддаг байна.

Нутгийн иргэдээс авсан мэдээллээр сохор элээ, өвөөлж, улаан хошуут жунгаа, хөх хэрээ, монгол болжмор, хээрийн бор шувуу, өвөгт тогоруу, нарийн хиазат, мөнгөлөг цахлай зэрэг шувуу судалгааны талбайн ойр орчимд тохиолддог байна.

Хөхтөн: Тус бүс нутагт Монгол-Оросын судлаачдын гаргасан дэлэнтэн амьтны тархалт нь нутгийн зурагт 14 зүйл, Монголын үндэсний атласт 10 зүйлийг тэмдэглэсэн байдаг байна. Нутгийн иргэдээс авсан мэдээллээр тус нутагт боролдой туулай, цайвар үлий, шивэр алагдаага, шар үнэг, хярс үнэг, цагаан зээр, дэлдэн зараа зэрэг амьтад тохиолддог байна.

Төслийн талбай нь Улаанбаатар-Замын Үүд чиглэлийн төмөр замын ойролцоо орших бөгөөд тухайн орчин нь хүн, мал, машин техникийн байнгын хөдөлгөөн болон дуу чимээ ихтэй тул томоохон хөхтөн амьтад байнга байршин амьдрах боломжгүй юм.

2.8. Нийгэм, эдийн засгийн үзүүлэлт

Улсын бага хурлын 1991 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 46 дугаар тогтоолоор Дорноговь аймгийн Сүмбэр сум, Шивээговь хороо, Улаанбаатар хотын Баянтал хороог нэгтгэн улсын зэрэглэлтэй Чойр хотыг байгуулж, улмаар УИХ-ын 1994 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн 32 дугаар тогтоолоор Чойр хотын хилийн цэсээр Говьсүмбэр аймгийг 1994 оны 08-р сард байгуулсан байна.

Говьсүмбэр аймаг нь Монгол улсын төвийн бүсийн зүүн өмнөд хэсэгт байрладаг бөгөөд Улаанбаатар хотоос зүүн өмнө зүгт 250 км-ийн зайд 5.5 мян.км² нутаг дэвсгэрийг хамран оршдог.

Хойд талаараа Төв аймгийн Баянцагаан, Баян, Баянжаргалан сумдтай зүүн ба зүүн хойд хэсгээрээ Хэнтий аймгийн Дэлгэрхаан, Дархан сумдтай, баруун болон баруун өмнөд хэсгээрээ Дундговь аймгийн Баянжаргалан, Цагаандэлгэр, Говь-Угтаал сумдтай тус тус хиллэдэг.

2019 оны жилийн эцсийн байдлаар Говьсүмбэр аймаг 17445 хүн амтай ба үүнээс эрэгтэй 8796, эмэгтэй 8649 байна. Өмнөх онтой харьцуулбал нийт хүн ам 44 буюу 0.3 хувиар, үүнээс эрэгтэй 2.9 хувиар, эмэгтэй 2.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Нийт хүн амын 50.1 хувийг эрэгтэйчүүд, 49.9 хувийг эмэгтэйчүүд эзэлж

байна. Нийт хүн амын 34.1 хувийг 0-15 насны хүүхэд, 60.3 хувийг хөдөлмөрийн насны буюу 16-59 насны хүмүүс, 5.6 хувийг өндөр настнууд буюу 60 ба түүнээс насны хүмүүс эзэлж байна.

2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр аймгийн хэмжээнд 1041 малтай өрх тоологдсоноос 712 малчин өрх, 329 малтай өрх тоологдсон байна. Малчин өрхөд 2371 хүн амьдарч байгаагаас 1164 малчин, үүнээс 509 нь эмэгтэй малчид байна.

Тус аймагт “Шивээ-Овоогийн нүүрсний уурхай”, “Ус-Ду”, “Тохижилт-Сүмбэр”, “Талын илч”, “Илчлэг-шивээ”, “Илчит сансар” зэрэг томоохон аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 2017 оны жилийн эцсийн байдлаар 52.2 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 54.1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулжээ.

Өмнөх онтой харьцуулбал бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 10.7 хувиар өссөн ба үүнд уул, уурхайн салбарын үйлдвэрлэлт голлон нөлөөлсөн байна. Харин бүтээгдэхүүн борлуулалт нь өмнөх оны мөн үеэс 20.6 хувиар өссөн байна.

2017-2018 оны хичээлийн жилийн байдлаар аймгийн хэмжээнд төрийн өмчийн 5, хувийн өмчийн 5 нийт 10 цэцэрлэгийн 41 бүлэгт 1800 хүүхэд байгаагаас эмэгтэй 881 хүүхэд хамрагдан хүмүүжиж байна.

2017-2018 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 5 сургуулийн 125 бүлэгт 3400 сурагч суралцаж байна.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Газрын гадарга болон хэвлий

Төслийн талбай орчмын газрын гадаргын ерөнхий төлөв байдлыг үзвэл урт хугацааны салхины элэгдлээр үүссэн дунд зэрийн зузаан давхаргатай үйрмэг чулуутай элсэнцэр гадаргуу зонхилох бөгөөд хүн амын суурьшлын бүсээс холгүй, мал ихээр бэлчээрлэдэг, төмөр зам дагуу байрлаж байгаа нь газрын гадарга талхлагдан доройтох нөхцөлийг үүсгэж байна. Ачилт, буулгалтын ложистик төв төсөл хэрэгжсэнээр төслийн талбайд бүх төрлийн ачаа бараа, машин техник буулгах тавцан байгуулах, гүүрэн кран байгуулах, агуулах барих гэх мэт барилга объектууд баригдах тул энэ үйл ажиллагаанд экскаватор, ачигч, зөөврийн ачааны машин зэрэг хүнд даацын машин механизм, тоног төхөөрөмжийг ашигладаг. Энэ нь төслийн талбайн газрын гадаргыг өөрчлөх, доройтуулах тул төслийн үйл ажиллагааны явцад газрын гадаргад үзүүлэх нөлөөллийг хамгийн бага байхаар төлөвлөх, учирсан хохирлыг тухай бүрт нь арилгах талаар төсөл хэрэгжүүлэгч анхаарч ажиллах нь зүйтэй юм.

Хөрс , ургамал

Төсөл хэрэгжиж эхэлсэнээр тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмж хүний үйл ажиллагаагаар эзэмшил талбайн хөрсөн бүрхэвч элэгдэл эвдрэлд өртөх, ургамлан нөмрөг нь доройтож устгах , хатуу шингэн хаягдлаар бохирдож болзошгүй байна.

Гадаргын болон газрын доорхи ус

Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн орчимд гадаргын усан сүлжээ байхгүй болно. Харин газрын доорхи усны чанарт төслийн үйл ажиллагаанаас хүчтэй сөрөг нөлөөлөл үзүүлэх хүчин зүйл байхгүй боловч газрын доорхи усны чанарт хяналт тавьж лабораторийн шинжилгээг тогтмол хийлгэж байх нь зүйтэй.

Агаар

Төслийн талбайн орчимд агаар бохирдуулж болзошгүй эх үүсвэрүүд нь элэгдэл эвдрэлд өртсөн хөрснөөс салхины үйлчлэл, төслийн талбайд хийгдэх механик ажил болон машин механизм, тээврийн хэрэгслийн хөдлөгөөнөөр агаарт тоосжилт дэгдэх, мөн техник хэрэгслийн дутуу шаталтат хөдөлгүүрээс агаарт хорт хий ялгарах , ахуйн хатуу , шингэн хаягдлаас агаарт бохирдол тархах зэрэг хүчин зүйлс байна.

Иймд эдгээр эх үүсвэрээс гарч болох сөрөг нөлөөлөлд тогтмол хяналт тавьж хорт хийг зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давуулахгүй

байх арга хэмжээг төсөл хэрэгжүүлэгч компанийн зүгээс төлөвлөн гүйцэтгэх, агаар бохирдуулагч бодисуудын агууламж стандартын түвшинээс давсан тохиолдолд мэргэжлийн байгууллагад хандан арилгах, бууруулах арга хэмжээ авах хэрэгтэй.

Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зөрчил

Төслийн үйл ажиллагааны үед ажилчид техник тоног төхөөрөмжтэй буруу харьцах, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл, саатлаас шалтгаалсан осол гарч болзошгүй юм. Иймд төслийн талбай дээр ажиллах үедээ мөрдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг баримтлах, төслийн ажилчдад ХХАА-ны сургалт, зааварчилгааг тогтмол өгч сургалт зохион байгуулах, тээврийн хэрэгсэл болон бусад тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавьж ажиллах хэрэгтэй.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт хэрэгжүүлж буй “Ачилт буулгалтын ложистик төв” төслийн Байгаль орчны менежментийн 2025 оны төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаварыг хянах, илрүүлэх үндсэн зорилготой юм.

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзо шгүй сөрөг нөлөөл лүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөл лийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Агаарт тоосжилт үүсгэх	Хүчтэй салхи болон шороон шуургатай үед ачилт буулгалтын үйл ажиллагааг түр зогсоох	Ачилт, буулгалтын талбай	-	-	-	-	Хүчтэй салхи, шуургатай үед	• БОННУ-ний тайлан /4.2.1/ • Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль • Машин механизмуудын аюулгүй ажиллагааны дүрэм
2.		Нүүрс буулгах талбай, автомашины зогсоолыг боломжит хэмжээгээр хатуу хучилттай болгох	Нүүрс буулгах талбай	-	-	1	Дотоод зардлаар	3-р улирал	
3.		Нүүрс буулгах талбайн салхины зонхилох чиглэлийн дээр саравч хийх ажлын үнийн судалгааг хийж мөн хэрэгжүүлэх ажлыг шат дараалалтай төлөвлөх	Нүүрс буулгах талбай	-	-	1	Дотоод зардлаар	3-р улирал	
4.	Шороон замаас тоос үүсч агаар бохирдуул ах	Төслийн талбай хүртэлх шороон зам дагууд замын анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулж тээврийн хэрэгслүүдийг зөвхөн нэг замаар зорчих нөхцлийг бүрдүүлэх, шинээр олон салаа зам үүсгэхгүй байх арга хэмжээ авах	Төслийн талбайн гадна	-	-	1	Дотоод зардлаар	2-р улирал	• Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм MNS 4596:2014
5.	Тээврийн хэрэгсэл, машин механизм ын нөлөөгөөр агаар бохирдох	Тээврийн хэрэгслүүдийг техникийн үзлэгт хамруулж ашиглалтын хугацаа дууссан болон дутуу шаталт үүсгэн хорт утаа ихээр ялгаруулж буй машин техникийг ашиглахгүй байх	-	-	-	-	150,000	2-р улирал	• Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598:2011 • Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага MNS 5885:2008 • Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS 4585:2016

6.	Хатуу, шингэн хаягдлыг ил задгай хаях, хөрс бохирдох	Хатуу шингэн хог хаягдлыг хуримтлуулах, зайлуулах арга хэмжээ авах, ил задгай хог хаягдал хаях, асгах, хур хог үүсэхээс урьдчилан сэргийлэх	Төслийн талбай	-	-	12	1,200,000	Сар бүр	- Хог хаягдлын тухай хууль - Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 5344:2011
7.	Шатах, тослох материал асгарч хөрс бохирдох	Шатах, тослох материал их бага хэмжээгээр асгарсан тохиолдолд элс, даавуу зэрэг шингээгч материалд шингээн авч битүү саванд хийх, асгарсан хэсгийн хөрсийг хуулан авч хөрсний гүн рүү нэвчихээс сэргийлэх	Төслийн талбай	-	-	Тухай бүр	-	Тухай бүр	Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019
8.	Ус хэрэглээ хяналтгүй байх	Ус ашиглуулах дүгнэлт гаргуулж гэрээ байгуулах, усны хэрэглээг тогтмол хянах	Оффисын барилга	-	50,000	1	50,000	1-р улирал	- Усны тухай хууль - Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А/156 дугаар тушаалын хавсралт "Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам"
Нийт, төгрөг							1,300,000		

ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, тө г	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Хөрс эвдэрч доройтох	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд шинээр мод тарих	Төслийн талбайд	Ширхэг	2,000	2,500	5,000,000	Хавар Намар	- Газрын тухай хууль - Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль “Тэрбум мод” хөдөлгөөн
2.		Мэргэжлийн байгууллагаас заавар зөвлөмж авч орон нутгийн цаг уурын онцлогт тохирсон мод бут тарих	Төслийн талбайд	-	-	-	-	Хавар Намар	
3.		Модны усалгаа, арчилгааг тогтмол хийж ургалтын хувийг нэмэгдүүлэх	Мод тарьсан талбай	-	-	-	Дотоод зардал	2-4-р улирал	
4.		Шинээр таригдсан мод бутыг тоолж бүртгэлжүүлэн акт үйлдэх	-	-	-	-	-	4-р улирал	
		Нийт, төгрөг					5,000,000		

ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөлөөлөлд өртөх түүх соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Түүх соёлын үл хөдлөх дурсгал, соёлын биет өв илрэх	Төслийн талбайд соёлын биет өв, түүх соёлын үл хөдлөх дурсгал илэрвэл нэн даруй үйл ажиллагааг зогсоож Сүмбэр сумын ЗДТГ болон бусад холбогдох байгууллагуудад нэн даруй мэдэгдэх	-	-	-	-	Илэрсэн тохиолдолд	• Соёлын өвийг хамгаалах тухай хууль
2.		Сумын ЗДТГ болон бусад холбогдох байгууллагын албан тушаалтан ирэх хүртэл түүх соёлын үл хөдлөх дурсгал, соёлын биет өвийг хөдөлгөхгүйгээр түр хамгаалах арга хэмжээ авах	-	-	-	-	Илэрсэн тохиолдолд	Соёлын өвийг хамгаалах тухай хууль

НАЙМ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Ахуйн	Хатуу хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах	Төслийн талбай	-	-	-	-	Тогтмол	Хог хаягдлын тухай хууль
2.	Ахуйн	Дахин боловсруулах боломжгүй ахуйн хаягдлыг сумын төвлөрсөн цэгт тээвэрлэх	Төслийн талбай	ш	-	12	-	Сар бүр	Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 534452011
3.	Ахуйн	Хог тээвэрлэх гэрээг жил бүр шинэчлэн байгуулж төлбөр тооцоог тогтсон хугацаанд төлөх	Төслийн талбай	ш	60,000	12	720,000	1-р улирал	Хог хаягдлын тухай хууль
4.	Ахуйн	Нэг удаагийн ахуйн хэрэглээнээс татгалзаж ахуйн хэрэглээний материалыг аль болох олон удаа ашиглах байдлаар үүсэж болох хаягдлыг бууруулах	Оффисын барилга	-	-	-	-	Тогтмол	БОННУ-ний тайлан /4.7/
5.	Аюултай	Машин механизмын ашиглалт, засвар үйлчилгээний үед гарах бензин, тос, шатах тослох материалын үлдэгдэл, сав, баглаа боодол, тосны шүүр аккумулятор зэрэг аюултай хог хаягдлыг тусгай саванд түр хадгалах, ашиглалтад байнгын хяналт тавьж ажиллах	Төслийн талбай	-	-	-	-	Тогтмол	Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам”
6.	Ахуйн	Хатуу, шингэн хог хаягдлын цэгийг тогтмол ариутгаж байх	Хог хаягдлын цэг	ш	30,000	2	60,000	2,4-р улирал	Хог хаягдлын тухай хууль
7.	Ахуйн	Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулах	Хог хаягдлын цэг	-	-	-	Үйл ажиллагааны зардал	3-р улирал	Хог хаягдлын тухай хууль
		Нийт, төгрөг					780,000		

ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
Агаарын чанарын мониторинг								
1	CO ₂ NO ₂ SO ₂	Нүүрсний талбай Оффисын барилгын орчим	2 удаа	2	49500	99,000		MNS 5885:2008 MNS 4585:2016
2	Тоос (нийт, PM10, PM2.5)	Нүүрсний талбай Оффисын барилгын орчим	2 удаа	2	48,000	96,000	-	MNS 5885:2008 MNS 4585:2016
Хөрсний чанааны мониторинг								
3	Хөрсний хүнд металлын агууламж /As, Cr, Cd, Cu, Pb, Ni, Fe, Zn/	Нүүрсний талбай Машины зогсоол	1 удаа	1	135,000	135,000	-	MNS 5850 : 2019 MNS 3297 : 1991
4	Нянгийн бохирдол Хөрсний ерөнхий шинжилгээ	Хатуу, шингэн хаягдлын цэг	1 удаа	1	45,000	45,000		
Усны чанарын мониторинг								
5	Усны химийн ерөнхий шинжилгээ:	Гүний худаг	2 удаа	2	60,000	120,000	-	MNS 0900:2018
6	Хаягдал ус	Бохирын цооног	2 удаа	2	70,000	140,000		
	Нийт					635,000		

**АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА,
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2025 он				
			Сар	Сар	Сар		
	1	2	3	4	5	6	7
1.	ХАБЭА-н инженер, Байгаль орчны мэргэжилтэн хариуцсан ажилтантай байх	-	Жилдээ			Хүний нөөц	-
2.	БОАЖС-ын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу 2025 оны төлөвлөгөөг боловсруулж БОУАӨЯ-аар батлуулах	-	1-р сар	-	-	Байгаль орчны мэргэжилтэн	-
3.	Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хугацаанд нь хүргүүлж дүгнүүлэх	-	11-р сар	-	-	Байгаль орчны мэргэжилтэн	-
4.	Байгаль орчныг хамгаалах чиглэлээр ажилтнуудын дунд сургалт зохион байгуулах	50,000		4-р сар		Байгаль орчны мэргэжилтэн	Төрийн байгууллагатай хамтрах
5.	Гал унтраах хэрэгслээр байгууллагыг бүрэн хангах арга хэмжээ авах	Дотоод зардлаар	2-р улирал			ХАБ	
6.	Газар, ус ашигласны төлбөр, хог хаягдлын төлбөрийг орон нутгийн төсвийн дансанд тухай бүр төлөх	250,000	Жилдээ			Нягтлан бодогч	
7.	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын ажлын хувцас, багаж хэрэгслээр бүрэн хангах	Үйл ажиллагааны зардал	Жилдээ			Удирдлага	
	Нийт, төгрөг	300.000					

**АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ
НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
	Сүмбэр сумын ИНХ	Сумын ИНХ-аар илтгэл тавьж, мэдээлэл өгөх	Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэл	Жилд 1 удаа	500,000	Салбар хариуцсан ажилтан	-
	Засаг даргын Тамгын газар	Харьяа нутаг дэвсгэрийн Захиргаанд төслийн байгаль хамгааллын ажлын талаар мэдээлэл өгөх	Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэл	Жилд 1 удаа	500,000	Салбар хариуцсан ажилтан	-
	БОАЖЯ	БО-г хамгаалах ажлын жилийн тайлан, төлөвлөгөөгөө БОАЖЯ-нд цаг тухайд нь гаргаж өгч байх	Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэл	Тогтмол	300,000	Салбар хариуцсан ажилтан	-
	Нийт				1,300,000		

АРВАН ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

№	Төлөвлөгдсөн ажил	Төсөв
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1,300,000
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	5,000,000
3	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	780,000
4	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	635,000
5	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, Зохион байгуулалтын төлөвлөгөө	300,000
6	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	1,300,000
Нийт төсөв		9,315,000